



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
№01 дүгээр сарын 12
№02 /623/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хууль

46

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

76

Монгол Улсын
Төрийн газрын
тогтоол

81

Шүүхийн шинжилгээний тухай

Төрийн өмчөөс орон нутгийн
өмчид эд хөрөнгө шилжүүлэх
тухай

“Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний
хоёр дахь хөтөлбөр батлах
тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|-----|---|----|
| 11. | Шүүхийн шинжилгээний тухай | 46 |
| 12. | Эрүүгийн байшаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай | 65 |
| 13. | Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 67 |
| 14. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 67 |
| 15. | Цагдаагийн байгууллагын тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай | 68 |
| 16. | Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 68 |
| 17. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 68 |
| 18. | Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 69 |
| 19. | Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 69 |
| 20. | Эзэлийн хэтэлцээр соёрхон батлах тухай | 70 |
| 21. | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай | 70 |
| 22. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 75 |
| 23. | Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 76 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|-----------|----|
| 24. | Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай | Дугаар 90 | 76 |
|-----|---|-----------|----|

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|--|------------|----|
| 25. | Зэвсэгт хүчний Жанжин штабын тайван цагийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 156 | 78 |
| 26. | Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 158 | 80 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|------------|----|
| 27. | "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хоёр дахь хөтөлбөр батлах тухай | Дугаар 303 | 81 |
|-----|---|------------|----|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүхийн шинжилгээ хийх үндэслэл, журам, зарим төрлийн шинжилгээний онцлог болон шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, шинжээчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Шүүхийн шинжилгээний тухай хууль тогтоомж

2.1.Шүүхийн шинжилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Эрүүгийн байцаан шийтгэх хууль², Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай³, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁴, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн шинжилгээ хийхэд энэ хуульд заасан журмыг баримтална.

4 дүгээр зүйл.Шүүхийн шинжилгээний зарчим

4.1.Шүүхийн шинжилгээ хийхэд дараахь зарчмыг баримтална:

4.1.1.хууль дээдлэх;

¹ Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Эрүүгийн байцаан шийтгэх хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

4.1.2.хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

4.1.3.хараат бус байх;

4.1.4.нууцыг хадгалах;

4.1.5.шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийх.

5 дугаар зүйл.Шүүхийн шинжилгээ хийх үндэслэл

5.1.Шүүхийн шинжилгээ хийх үндэслэл нь шинжилгээ хийлгэх тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, төрийн эрх бүхий байгууллагын хүсэлт байна.

5.2.Шүүхийн шинжилгээний байгууллагаас хийсэн шинжилгээний талаар иргэн, байгууллагаас гаргасан гомдол, хүсэлт нь дахин шинжилгээ хийх шууд үндэслэл болохгүй.

6 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

6.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

6.1.1."шүүхийн шинжилгээ" гэж эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааг;

6.1.2."шинжээч" гэж шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн этгээдийг;

6.1.3."шүүхийн шинжилгээний мэргэжилтэн" гэж криминалистикийн болон эмнэлгийн тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох эрх бүхий, шинжилгээний байгууллагын ажилтныг;

6.1.4."шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд" гэж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, шүүхийг болон хуульд заасан төрийн эрх бүхий байгууллагыг;

6.1.5."шинжээчийн дүгнэлт" гэж шинжээч өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд хийсэн шинжилгээний явц, үр дүнг тусгасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг;

6.1.6."шинжилгээний магадлагаа" гэж эрх бүхий байгууллагаас гаргасан хүсэлтийг үндэслэн хийсэн анхан шатны үзлэг, оношлогооны үр дүнг тусгасан баримт бичгийг;

6.1.7."шинжилгээний объект" гэж шинжилгээ хийж байгаа

ул мөр, эд мөрийн баримт, бичиг баримт, эд юмс, амьтан, хүний бие, цогцос болон түүний хэсэг, харьцуулан судлах хэв загвар, хэргийн бусад материалыг;

6.1.8. "харьцуулан шинжлэх хэв хэлбэр буюу дээж" гэж шинжлэгдэж байгаа хүн, амьтан, цогцос, материал, эд юмс, бодис зэргийн шинж чанар, онцлогийг тусгасан, шинжилгээ хийж дүгнэлт гаргахад шинжээнд зайлшгүй шаардлагатай, хуульд заасан журмын дагуу хураан авагдсан объектыг;

6.1.9. "шинжилгээний объектын гэмтэл буюу хоротдол" гэж лабораторийн шинжилгээ болон үзлэг, шинжилгээний явцад физик, хими, биологийн аргуудыг хэрэглэсний улмаас объектын хэлбэр, хэмжээ, шинж чанар алдагдаж, өөрчлөлт орохыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ

7 дугаар зүйл. Шүүхийн шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах

7.1 Шүүхийн шинжилгээ /цаашид "шинжилгээ" гэх/ хийлгэх шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж, төрийн эрх бүхий байгууллага хүсэлт гаргана.

7.2 Шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтэд дараахь зүйлийг тусгана.

- 7.2.1 шинжилгээ хийлгэх үндэслэл;
- 7.2.2 шинжилгээ хийлгэх байгууллагын нэр,
- 7.2.3 шинжилгээ хийх хугацаа;
- 7.2.4 шинжээнд тавих асуулт;
- 7.2.5 шинжилгээний объектын талаархи мэдээлэл.

8 дугаар зүйл. Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаар хийлгэх

8.1 Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтийг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлнэ.

8.2 Шүүхийн шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтийг хүлээн авч, шинжээчийн мэргэжил, ажлын дадлага, туршлага, мэргэшсэн байдал, эрдмийн зэрэг, иол, ажлын ачаалал зэргийг харгалзан тухайн хэрэгт хувийн сонирхолгүй шинжээнд шинжилгээ хийлгэхээр хуваарилна.

8.3 Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжээнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, дүгнэлт гаргахаас татгалзах буюу зайлсхийх,

эсхүл санаатайгаар худал дүгнэлт гаргавал түүнд хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

8.4.Шинжилгээ хийх журмыг шинжилгээний төрлөөс хамааран хууль зүйн, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

9 дүгээр зүйл. Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх

9.1.Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлт гаргаж, шинжилгээ хийхээр томилогдож байгаа шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан ажиллагааг явуулсны дараа харшлах шалтгаан байхгүй гэж үзвэл шинжээчид шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтийг гардуулан өгч, эрх, үүрэг, хариуцлагыг нь урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасны дагуу шинжээчээр томилогдсон этгээд нь шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн дуудсанаар ирж, тавьсан асуулыг дагуу дүгнэлт гаргана.

9.4.Шинжээч шинжилгээний явцад ямар нэгэн хүсэлт гаргавал түүнийг томилсон этгээд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан журмын дагуу тэмдэглэл үйлдэх үүрэгтэй.

10 дугаар зүйл. Шинжилгээний объект, түүнд тавих шаардлага

10.1.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжилгээний объектыг шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтийн хамт шүүхийн шинжилгээний байгууллага, эсхүл шинжээчид хүргүүлнэ.

10.2.Шинжилгээний объект нь шинж чанараа амархан алдах, устаж үгүй болохоор байвал түүнийг бэхжүүлж авсны дараа нэн даруй шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлж хадгалуулна.

10.3.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжилгээний объектыг шинжилгээ хийх байгууллага, шинжээчид хүргүүлэх боломжгүй

бол шинжээчийг шинжилгээний объектод чөлөөтэй нэвтрэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангах үүрэгтэй.

10.4 Шинжилгээний объект нь дараахь шаардлагыг хангасан байна:

10.4.1. шинжилгээ хийхэд шаардагдах тоо хэмжээ, чанарын үзүүлэлтийг хангасан байх;

10.4.2. эх хувь буюу биет байдлаар, эсхүл шинжилгээний шаардлага хангахуйц бусад хэлбэртэй байх;

10.4.3. эдийн засгийн холбогдолтой шинжилгээний материалын хувьд эрх бүхий байгууллагын акт, дүгнэлт гарсан байх.

10.5. Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11 дүгээр зүйл. Шинжилгээ хийх хугацаа

11.1. Шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтийг шүүхийн шинжилгээний байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн шинжилгээ хийж дуусгах хугацааг тооцно.

11.2. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно.

11.3. Шинжээч нь энэ хуулийн 11.2-т заасны дагуу тогтоосон хугацаанд шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй бол шинжилгээ хийх хугацааг сунгуулах тухай хүсэлтээ шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд гаргана.

11.4. Энэ хуулийн 11.3-т заасан хүсэлтийг хүлээн авсан этгээд шүүхийн шинжилгээ хийх хугацааг мөн хуулийн 11.2-т заасныг үндэслэн сунгана.

12 дугаар зүйл. Шинжилгээ хийх журам

12.1. Шинжээч нь хүлээн авсан шинжилгээний объектыг гэрэл зураг болон бусад арга хэрэгслээр бэхжүүлэн авсны дараа батлагдсан аргачлалын дагуу шинжилгээ хийнэ.

12.2. Шинжилгээнд ирүүлсэн объект гэмтэж, устаж үгүй болохоор байвал шинжээч шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд энэ талаар урьдчилан мэдэгдэнэ.

12.3.Шинжээч нь шаардлагатай тохиолдолд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмыг баримтлан харьцуулан шинжлэх хэв хэлбэр буюу дээж авч дүгнэлт гаргахдаа ашиглах эрхтэй.

12.4.Шинжээч харьцуулан шинжлэх хэв хэлбэр буюу дээжийг шинжилгээ дууссаны дараа шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд буцаах, эсхүл тодорхой хугацаагаар шүүхийн шинжилгээ хийсэн байгууллагад хадгалж болно.

12.5.Шинжилгээ хийж дууссаны дараа шинжээч нь шинжээчийн дүгнэлт, гэрэл зургийн үзүүлэлт, буцаах баримт материалыг шүүхийн шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтанд танилцуулснаар шинжилгээг дууссанд тооцно.

12.6.Шинжилгээ хийх явцад шинжилгээний объект гэмтсэн, устаж үгүй болсон нь шүүхийн шинжилгээний байгууллага, шинжээчийн буруутай холбоогүй бол хохирлыг нь шүүхийн шинжилгээний байгууллага, шинжээч хариуцахгүй.

13 дугаар зүйл. Шинжээчийн эрх

13.1.Шинжээч дараахь эрх эдэлнэ:

13.1.1.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан үндэслэлээр шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас татгалзах;

13.1.2.шинжилгээ хийхэд шаардлагатай баримт материалтай танилцах;

13.1.3.шинжилгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай нэмэлт материал гаргаж ирүүлэхийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс хүсэх;

13.1.4.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зөвшөөрснөөр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчийг байцаахад байлцах;

13.1.5.дүгнэлт гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зөвшөөрснөөр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчид асуулт тавих;

13.1.6.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжээчийн энэ хуульд заасан эрхийг зөрчөөл Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмын дагуу гомдол гаргах;

13.1.7.хуульд заасан бусад эрх.

14 дүгээр зүйл. Шинжээчийн үүрэг

14.1.Шинжээч дараахь үүрэг хүлээнэ:

14.1.1.шинжилгээг тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд тал бүрээс нь бүрэн, бодитой хийх;

14.1.2. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуултын дагуу шинжилгээ хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах;

14.1.3. хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийг хүндэтгэн хүнлэг харьцах;

14.1.4. шинжилгээ хийх явцад инэрхий болсон төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;

14.1.5. хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар дүгнэлтдээ тусгах;

14.1.6. шинжилгээнд ирүүлсэн шинжилгээний объектын бүрэн бүтэн байдлыг хариуцах;

14.1.7. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон бусад этгээдээс хараат бус байж, гэгцхүү хуульд захирагдах;

14.1.8. хуульд заасан бусад үүрэг.

15 дугаар зүйл. Шинжээчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

15.1. Шинжээчид дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

15.1.1. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс бусад этгээдийн хүсэлт, шийдвэрээр шинжилгээ хийх;

15.1.2. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг үндэслэн дүгнэлт гаргах;

15.1.3. тухайн шинжилгээтэй холбогдолгүй асуудлаар хэргийн оролцогчоос тайлбар, тодорхойлолт авах;

15.1.4. шинжилгээ хийхийн тулд өөрийн санаачилгаар баримт материал цуглуулах;

15.1.5. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс бусад этгээдэд шинжилгээний үр дүнгийн талаар мэдээлэх;

15.1.6. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэлгүйгээр шинжилгээний объектыг гэмтээх, устгах, эсхүл түүний шинж чанарыг өөрчлөх;

15.1.7. шинжилгээний явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах, түүнийг хувийн сонирхлоор ашиглах;

15.1.8. тодорхой шинжилгээ хийсэнтэй холбогдуулан бусад байгууллага, иргэнээс шагнал, шан харамж авах;

15.1.9. шинжилгээ дууссаны дараа шинжилгээний объектыг өөртөө хадгалах.

16 дугаар зүйл. Шинжээчийг татгалзан гаргах

16.1. Шинжээч нь дараахь үндэслэл байвал шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас татгалзана:

16.1.1. урьд нь уг хэргийг байцаан шийтгэх болон хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, гэрч, хохирогч,

тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, орчуулагч, хэлмэрчний хувиар оролцсон;

16.1.2.байцаан шийтгэх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн төрөл садан байвал;

16.1.3.шинжээч нь албан тушаалын болон бусад талаар хэргийн оролцогчийн эрхшээлд байгаа бол;

16.1.4.хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;

16.1.5.шинжээчээс тухайн хэргийн талаар хийсэн шалгалтын материал нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болсон бол;

16.1.6.шинжилгээний объект нь шинжилгээ хийж дүгнэлт гаргах шаардлага хангахгүй байгаа бол;

16.1.7. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуулт шинжээчийн тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн, эсхүл тавьсан асуултад шинжлэх ухааны арга, хэрэгсэл ашиглан хариулах боломжгүй бол.

16.2 Энэ хуулийн 16.1.6, 16.1.7-д заасан үндэслэл байвал шинжээч үндэслэлээ тодорхой зааж шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас татгалзаж, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд энэ тухайгаа нэн даруй мэдэгдэнэ.

16.3 Шинжээч энэ хуулийн 16.1.1-16.1.5-д заасан үндэслэлээр шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас татгалзвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэхээр өөр шинжээчийг томилно.

16.4 Энэ хуулийн 16.1.1-16.1.4-т заасан үндэслэл байвал хэргийн оролцогч, түүний хууль ёсны төлөөлөгч шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг гаргаж болно.

16.5 Шинжээчийг татгалзан гаргах хүсэлтийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 56.4-т заасан журмаар шийдвэрлэнэ.

17 дугаар зүйл. Шинжээч дүгнэлт гаргах

17.1.Шинжээч шинжилгээний явц, үр дүнг үндэслэн дүгнэлтээ бичгээр гаргаж, гарын үсэг зурна.

17.2.Шинжээчийн дүгнэлт нь шинжилгээний бодит үр дүнг тусгасан, шинжлэх ухааны тодорхой арга зүйд тулгуурласан, шинжээчийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд хийгдсэн байна.

17.3.Шинжээчийн дүгнэлтийг шинжээчийн хувийн болон байгууллагын тэмдгээр баталгаажуулснаар хүчинтэйд тооцно.

17.4.Шинжээч өөрийн гаргасан дүгнэлтийн үнэн зөвийг хариуцна.

17.5.Шинжээч дүгнэлтээ хоёр хувь үйлдэж нэгийг нь шинжээчийг томилсон этгээдэд хүргүүлж, үлдэх хувийг шүүхийн шинжилгээний байгууллагын архивт хадгалуулна.

17.6.Шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэсэн тохиолдолд шинжээчийн дүгнэлтийг тухайн байгууллагын тэмдэг, шинжээчийн гарын үсгээр баталгаажуулна.

18 дугаар зүйл. Шинжээчийн дүгнэлтийн агуулга

18.1.Шинжээчийн дүгнэлтэд дараахь зүйлийг тусгана:

18.1.1.шинжилгээ хийсэн он, сар, өдөр, газар;

18.1.2.шинжилгээ хийх болсон үндэслэл;

18.1.3.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн талаархи мэдээлэл;

18.1.4.шинжилгээ хийсэн шинжээчийн талаархи мэдээлэл /овог, нэр, боловсрол, мэргэжил, ажилласан жил, эрдмийн зэрэг, цол, албан тушаал/;

18.1.5.санаатайгаар худал дүгнэлт гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг сануулсан тэмдэглэл;

18.1.6.шинжилгээний объект ба хэргийн материалыг шинжилсэн явц;

18.1.7.шинжилгээний явцад байлцсан хэргийн оролцогчийн талаархи мэдээлэл;

18.1.8.шинжээчид тавьсан асуулт, түүнд өгсөн хариулт, түүний үндэслэлийг асуулт тус бүрээр;

18.1.9.хүний биед хийсэн шинжилгээний дүгнэлтэд шинжилгээ хийлгэсэн этгээдээс шинжилгээ хийхэд шаардлагатай харьцуулан шинжлэх хэв хэлбэр буюу дээжийг авсан тухай мэдээлэл.

18.2.Шинжилгээний явцад хэрэглэсэн арга, аргачлал, тэдгээрийн үр дүнг харуулсан гэрэл зургийн үзүүлэлт бүхий материал нь шинжээчийн дүгнэлтийн бүрэлдэхүүн хэсэг болох ба гэрэл зургийн үзүүлэлтийг хоёр хувь үйлдэн нэг хувийг шүүхийн шинжилгээний байгууллагын архивт хадгалуулна.

19 дүгээр зүйл. Нэмэлт шинжилгээ хийх

19.1.Шинжээчийн дүгнэлт тодорхойгүй буюу бүрэн бус, эсхүл шинжилгээ хийлгэж байгаа асуудалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, захирамж, хүсэлтээр нэмэлт шинжилгээ хийнэ.

19.2.Нэмэлт шинжилгээг энэ хуулийн 19.1-д заасан дүгнэлтийг гаргасан буюу гаргахад оролцсон шинжээчээр хийлгэж болно.

19.3.Нэмэлт шинжилгээ хийх хугацааг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу тооцно.

20 дугаар зүйл. Дахин шинжилгээ хийх

20.1.Шинжээчийн дүгнэлт, эсхүл түүний зарим хэсэг үндэслэлгүй буюу үнэн зөв болох нь эргэлзээтэй байвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, захирамж, хүсэлтээр дахин шинжилгээ хийнэ.

20.2.Дахин шинжилгээ хийхэд энэ хуулийн 20.1-д заасан дүгнэлтийг гаргасан буюу гаргахад оролцсон шинжээчийг оролцуулахыг хориглоно.

20.3.Дахин шинжилгээ хийх хугацааг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу тооцно.

21 дүгээр зүйл. Шинжилгээг бүрэлдэхүүнээр хийх

21.1.Шаардлагатай тохиолдолд шинжилгээг ижил буюу өөр өөр мэргэжлийн хоёроос дээш шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр хийлгэж болно.

22 дугаар зүйл. Ижил мэргэжлийн шинжээчдийн бүрэлдэхүүнтэйгээр шинжилгээ хийх

22.1.Ижил мэргэжлийн шинжээчдийн бүрэлдэхүүнтэйгээр шинжилгээ хийх үед шинжээч тус бүр шинжилгээг эхнээс нь дуустал бие дааж хийх бөгөөд шинжилгээний эцэст үр дүнгээ нэгтгэн дүгнэлт гаргана.

22.2.Шинжилгээний дэс дараалал, цар хүрээ, арга зүйг шинжээчид харилцан зөвшилцсөний үндсэн дээр тогтооно.

22.3.Шинжилгээний үр дүнгийн талаар шинжээчид нэгдсэн саналд хүрсэн бол нэг дүгнэлт гаргах ба санал зөрсөн тохиолдолд санал зөрсөн шинжээч тусгай саналаа дүгнэлтэд хавсаргана.

23 дугаар зүйл. Өөр өөр мэргэжлийн шинжээчдийн бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийх

23.1.Өөр өөр мэргэжлийн шинжээчдийн бүрэлдэхүүнтэйгээр шинжилгээ хийх үед шинжээч тус бүр өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийнэ.

23.2.Шинжээчийн дүгнэлтэд шинжээч тус бүрийн хийсэн

шинжилгээний төрөл, агуулга, гаргасан дүгнэлтийг тусгана.

23.3 Шинжилгээнд оролцсон шинжээч тус бүр зөвхөн өөрийн хийсэн шинжилгээг тусгасан дүгнэлтийн хэсэгт гарын үсэг зурж, түүнийхээ төлөө хариуцлага хүлээнэ.

23.4 Шинжилгээний явцад шинжээчид ижигт дүгнэлтэд хүрсэн бол энэ тухай дүгнэлтэд тэмдэглэнэ.

23.5 Шинжээчид санал зөрсөн тохиолдолд энэ хуулийн 22.3-т заасны дагуу дүгнэлт гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗАРИМ ТӨРЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ

24 дүгээр зүйл. Криминалистикийн шинжилгээний онцлог

24.1 Криминалистикийн шинжилгээнд шинжилгээний объект, бусад шаардлагатай баримт материалыг эх хувиар нь ирүүлнэ.

24.2 Тэсэрч дэлбэрэх бодис, сум, галт хэрэгсэл, цацраг идэвхт үүсгүүр, хими, биологийн болон аюул учруулж болзошгүй бусад объектод зориулалтын төхөөрөмжөөр тоноглож аюулгүй байдлыг хангасан орчинд тогтоосон журмын дагуу шинжилгээ хийнэ.

25 дугаар зүйл. Шүүх эмнэлгийн шинжилгээний онцлог

25.1 Шүүх эмнэлгийн шинжилгээг шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллага, албадан саатуулах байр, цагдан хорих байр, хорих анги, эрүүлжүүлэх байранд хийж болно.

25.2 Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх зааврыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

26 дугаар зүйл. Сэтгэцийн шинжилгээний онцлог

26.1 Дараахь тохиолдолд сэтгэцийн шинжилгээ хийнэ:

26.1.1 Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 156.1.3, 156.1.4-т заасан;

26.1.2 иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч, хариуцагч /иргэн/ нь иргэний эрх зүйн чадамжтай эсэхэд эргэлзээ төрвөл тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлох;

26.1.3 иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч нь хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитойгоор тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл тэдний

сэтгэцийн байдлыг тодорхойлох;

26.1.4 гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн хувьд эрүүл байсан боловч шийтгэх тогтоол гаргахын өмнө сэтгэцийн өвчнөөр өвчилсөн болон урьд нь сэтгэцийн өвчтэй, хэрэг хариуцах чадваргүй гэж тогтоогдсон этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тогтоох;

26.1.5 ял эдэлж байх үедээ сэтгэцийн өвчнөөр өвчилсөн ялтанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тогтоох.

26.2. Шинжээч сэтгэцийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа сэтгэцийн үзлэг, шинжилгээний дүн материалаас гадна урьд нь тухайн этгээдийн эмчлүүлж, шинжлүүлж байсан эмнэлгийн баримт бичгийг үндэслэнэ.

27 дугаар зүйл. Эдийн засгийн шинжилгээний онцлог

27.1. Эрүү, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараахь нөхцөл байдал илэрсэн тохиолдолд эдийн засгийн шинжилгээ хийнэ:

27.1.1. баримтын шалгалтаар тогтоосон эд хөрөнгийн дутагдал буюу илүүдэл нь тухайн хэргийн бодит байдалтай тохирохгүй байгаа;

27.1.2. эд хөрөнгийн дутагдал буюу илүүдлийн хэмжээг баримтын шалгалт хийсэн улсын байцаагч үнэн зөв, бодитой тодорхойлж чадаагүй нь мөрдөн шалгах ажиллагааны явцад илэрсэн;

27.1.3. анхны тооцоо бодсон акт, баримт сэлтийг эрх бүхий байгууллагаас дахин шалгаж тогтоосон акт нь тухайн хэргийг шийдвэрлэх хангалттай үндэслэл болж чадахгүй байгаа;

27.1.4. баримтын шалгалтаар тавьсан акт буюу эрх бүхий байгууллагын дахин шалгаж тогтоосон акт буруу гэдгийг холбогдох этгээд тодорхой баримтаар нотолсон.

27.2. Эдийн засгийн шинжилгээ хийж байгаа шинжээч нь баримтын шалгалт дахин хийх буюу тооллого явуулах эрх эдлэхгүй.

27.3. Эдийн засгийн шинжилгээний стандартыг шүүхийн шинжилгээний төв байгууллагын дарга батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮНИЙ БИЕД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

28 дугаар зүйл. Хүний биед шинжилгээ хийх үндэслэл

28.1. Хүний биед хийх шинжилгээг эрүү, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хийнэ.



28.2.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 156 дугаар зүйлд заасан үндэслэлээр хүний биед шинжилгээ хийх шаардлагатай гэж үзвэл шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд тогтоол, захирамж, хүсэлт гаргана.

28.3.Энэ хуулийн 28.2-т зааснаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний биед шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж үзвэл шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

29 дүгээр зүйл. Хүний биед шинжилгээ хийх нөхцөл

29.1.Хүний биед хийх шинжилгээг шинжилгээ хийх болон шинжилгээ хийлгэх этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хангасан орчин, нөхцөлд хийнэ.

29.2.Хүний биед хийх шинжилгээг шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллага, албадан саатуулах, баривчлах, цагдан хорих байр болон хорих ангид хийж болно.

29.3.Шинжилгээ хийлгэх этгээд нь шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллагад хүрэлцэн ирэх боломжгүй хүндээр өвчилсөн, гэмтсэн тохиолдолд шинжээч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хамт тухайн этгээдийн байгаа газарт нь очиж шинжилгээ хийж болно.

29.4.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 161 дүгээр зүйлд заасны дагуу шинжилгээ хийлгэх этгээдийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулан шинжилгээ хийж болно.

29.5.Шинжилгээ хийлгэх этгээдийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ.

29.6.Шинжилгээ хийлгэх этгээд нь 16 насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон бол түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг авсан байна.

30 дугаар зүйл.Шинжилгээ хийлгэх этгээдийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах үндэслэл, журам

30.1.Шүүх эмнэлгийн, эсхүл сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлт гаргахын тулд шинжилгээ хийлгэх этгээдийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 161 дүгээр зүйлд заасан үндэслэл, журмын дагуу эрүүл мэндийн байгууллагад байрлуулж болно.

30.2.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

30.3.Энэ хуулийн 30.1-д заасан үндэслэлээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулсан бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл садангийн хүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх ба энэ тухай шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамжид тэмдэглэнэ.

31 дүгээр зүйл.Шинжилгээ хийлгэх этгээдийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацаа

31.1.Шинжилгээ хийж дүгнэлт гаргахын тулд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг энэ хуулийн 11.2-т заасан хугацаагаар эрүүл мэндийн байгууллагад байрлуулна.

31.2.Шаардлагатай тохиолдолд шинжээчийн үндэслэл бүхий хүсэлтийг үндэслэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацааг энэ хуулийн 11.4-т заасан хугацаагаар сунгаж болно.

31.3.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор шийдвэрлэж, шинжээчид хүргүүлнэ.

31.4.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацааг сунгахаас татгалзсан бол шинжилгээ хийлгэх этгээдийг нэн даруй эмнэлгээс гаргана.

32 дугаар зүйл.Цагдан хоригдоогүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид сэтгэцийн шинжилгээ хийх

32.1.Сэтгэцийн шинжилгээ хийлгэх шаардлагатай цагдан хоригдоогүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байрлуулж шинжилгээ хийнэ.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасны дагуу шинжилгээ хийлгэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хүний амь нас, эрүүл мэндийг хохироох, эмнэлгийн үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй үйлдэл хийсэн бол цагдаагийн байгууллагад мэдэгдэж, үйлдлийг нь таслан зогсоох арга хэмжээ авна.

32.3.Өөрийн хүсэлтээр шинжилгээ хийлгэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч энэ хуулийн 32.2-т заасан үйлдлийг хийсэн бол уг этгээдийг эмнэлгийн захиргаа эмнэлгээс гаргаж, энэ тухай шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

33 дугаар зүйл. Цагдан хоригдож байгаа этгээдэд сэтгэцийн шинжилгээ хийх

33.1 Цагдан хоригдож байгаа этгээдэд хийх сэтгэцийн шинжилгээг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт хийх бөгөөд эмнэлгийн аюулгүй байдал, хамгаалалтыг цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага хариуцна.

34 дүгээр зүйл. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

34.1 Хүний биед шинжилгээ хийхэд дараахь зүйлийг хориглоно:

34.1.1.сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс мэдээлэл авах зорилгоор эрхийг нь хязгаарлах, хуурч мэхлэх, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх болон бусад хууль бус арга хэрэглэн шинжилгээ хийх.

34.1.2.сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн биед шинэ эм, эмчилгээ, түүнчлэн оношлогооны болон өөрчлөх урьдчилан сэргийлэх шинэ арга хэрэгсэл турших, эмнэлгийн туршилтын шинжилгээ хийх;

34.1.3.сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг урьд нь эмчилж байсан эмчийг шинжилгээнд оролцуулах;

34.1.4.шинжилгээний явцад олж мэдсэн, шинжилгээний объектод хамаарахгүй асуудлаар мэдүүлэг өгөхийг шинжээчээс шаардах.

34.2 Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь шинжилж байгаа зүйлийн талаар шинжээчид тайлбар өгөх эрхтэй.

34.3 Шаардлагатай тохиолдолд шинжилгээ хийлгэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид Эрүүл мэндийн тухай хууль¹ болон түүнд нийцүүлэн гаргасан журмын дагуу эмнэлгийн тусламж үзүүлнэ.

35 дугаар зүйл. Хүний биед хийх шинжилгээний аргад тавих хязгаарлалт

35.1 Хүний биед шинжилгээ хийхдээ эмнэлгийн практикт хэрэглэгдээгүй болон хэрэглэхийг хориглосон арга хэрэглэхийг хориглоно.

35.2 Шинжээч нь хэрэглэх шинжилгээний арга, үүсч болзошгүй өвдөлт, сөрөг нөлөөний тухай сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өөрт нь болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

35.3 Шинжилгээнд шаардагдах хэв хэлбэр буюу дээжийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс эмнэлгийн байгууллагад авч энэ тухай шинжээчийн дүгнэлтэд тусгана.

35.4 Шинжилгээнд шаардагдах хэв хэлбэр буюу дээж авахдаа шинжээч нь эмнэлгийн байгууллагын хоёр ажилтныг хөндлөнгийн гэрчээр

¹ Эрүүл мэндийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

байлцуулна.

36 дугаар зүйл. Хүний биед хийх шинжилгээний үед хэргийн оролцогчийг байлцуулах

36.1. Хүний биед шинжилгээ хийх үед шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн зөвшөөрснөөр хэргийн бусад оролцогчийг байлцуулж болно.

36.2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг нүцэглэх шаардлагатай бол зөвхөн түүнтэй ижил хүйсийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчийг байлцуулж болох ба энэ хязгаарлалт нь шинжилгээ хийхэд оролцож байгаа эмч, эмнэлгийн бусад ажилтанд хамаарахгүй.

**ТАВДУГААР БҮЛЭГ
ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ТОГТОЛЦОО,
ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ
ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

37 дугаар зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо

37.1. Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

37.2. Шүүхийн шинжилгээний байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана.

37.3. Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ.

37.4. Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно.

38 дугаар зүйл. Шүүхийн шинжилгээний төв байгууллагын чиг үүрэг

38.1. Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

38.1.1. аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албыг

мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

38.1.2.шүүхийн шинжилгээний байгууллагын хүний нөөцийн бодлого боловсруулах, албан хаагчийг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

38.1.3.шүүхийн шинжилгээний байгууллагыг техник, тонсг төхөөрөмжөөр хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

38.1.4.үндсэн чиг үүргийн хүрээнд дотоод, гадаадын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллах;

38.1.5.шүүхийн шинжилгээ хийхэд мөрдөх журам, заврын биелэлтийг зохион байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих.

39 дүгээр зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын санхүүжилт

39.1.Шүүхийн шинжилгээний байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

39.2.Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа үйлчилгээний хөлс авч болох бөгөөд үйлчилгээний хөлснөөс олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

39.3.Энэ хуулийн 39.2-т заасан шинжилгээ хийх журам, үйлчилгээний хөлсний хэмжээг хууль зүйн, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

40 дүгээр зүйл. Шүүхийн шинжилгээний мэдээллийн сан

40.1. Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь улсын хэмжээний шүүхийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сантай байна.

40.2. Шүүхийн шинжилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41 дүгээр зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан

41.1.Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээч, мэргэжилтэн ажиллана.

41.2.Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтнээр ял шийтгэлгүй, шинжилгээний чиглэлээр мэргэшсэн Монгол Улсын иргэнийг томилно.

41.3. Шинжээн нь тогтоосон загварын дагуу үйлдсэн хувийн дугаар бүхий тусгай тэмдэг хэрэглэнэ.

41.4. Шинжээн, мэргэжилтний мэргэшлийн түвшинг тодорхойлох аттестатчиллыг 5 жил тутамд явуулна.

41.5. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтныг аттестатчилах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42 дугаар зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тангараг, дүрэмт хувцас, цол

42.1. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан "Монгол Улсын иргэн би шүүхийн шинжилгээний байгууллагад орж ажиллахдаа хуулийг дээдлэн биелүүлж, гагцхүү шинжлэх ухааны бодит үнэнд захирагдан үнэнчээр ажиллаж, төрийн тусгай албан хаагчийн сахилга, ёс зүйг чанд сахихаа батлан тангараглая. Би энэ тангарагаасаа няцваас хуулийн хариуцлага хүлээнэ" гэж Төрийн сүлдэнд тангараг өргөнө.

42.2. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тангараг өргөх ёслолын журмыг Төрийн албаны тухай хуулийн⁶ 12.2-т заасны дагуу зохицуулна.

42.3. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь цагдаагийн дүрэмт хувцас, цол хэрэглэж, ялгах тэмдэгтэй байх ба тэдгээрийг хэрэглэх журмыг Засгийн газар батална.

43 дугаар зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа

43.1. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана.

43.2. Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно.

43.3. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай⁷ хуулиар зохицуулна.

⁶ Төрийн албаны тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

43.4 Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно.

43.5 Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

44 дүгээр зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах

44.1. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтанд гаргасан зөрчлийнх нь шинж байдлыг харгалзан дараахь сахилгын шийтгэл ногдуулна:

44.1.1. сануулах;

44.1.2. албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

44.1.3. цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах;

44.1.4. цол бууруулах буюу хасах;

44.1.5. ажлаас халах.

44.2. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны сахилгын дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

45 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

45.1. Шүүхийн шинжилгээний тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

45.2. Шүүхийн шинжилгээний тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь хариуцлага хүлээлгэнэ:

45.2.1. энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр торгох;

45.2.2. энэ хуулийн 20.2, 28-32 дугаар зүйл, 34 дүгээр зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр, байгууллагыг 100000-500000 төгрөгөөр тус тус торгох;

45.2.3. энэ хуулийн 35 дугаар зүйлд заасныг зөрчсөн шинжээчийг 50000-150000 төгрөгөөр торгох;

45.2.4 энэ хуулийн 43.4-т заасныг зөрчсөн иргэнийг 5000-50000, албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр тус тус торгох;

45.2.5 энэ хуулийн 43.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр, байгууллагыг 100000-500000 төгрөгөөр тус тус торгох;

45.2.6 шинжилгээний объектыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр устгасан шинжээчийг 50000-150000 төгрөгөөр торгох.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 57 дугаар зүйл:

"57 дугаар зүйл. Шинжээчээр оролцож болохгүй байдал

57.1. Шинжээч Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16.1-д заасан үндэслэл байвал байцаан шийтгэх ажиллагаанд оролцож болохгүй."

2/ 155 дугаар зүйлийн 155.1, 155.2 дахь хэсэг:

"155.1. Шинжилгээ хийлгэхэд энэ хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

155.2 Шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах бөгөөд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамжид Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 7.2-т заасан зүйлийг тусгасан байна."

3/ 158 дугаар зүйл:

"158 дугаар зүйл. Шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх

158.1. Шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэхэд

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтална.”;

4/ 159 дүгээр зүйл:

“159 дүгээр зүйл. Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх

159.1. Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэхэд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан үндэслэл, журмыг баримтална.”;

5/ 161 дүгээр зүйлийн 161.2 дахь хэсэг:

“161.2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт шилжүүлэх бол прокурорын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.”;

6/ 162 дугаар зүйлийн 162.2 дахь хэсэг:

“162.2 Шинжээчийн дүгнэлтэд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан зүйлийг тусгасан байна.”;

7/165 дугаар зүйл:

“165 дугаар зүйл. Нэмэлт ба дахин шинжилгээ хийх

165.1. Нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэхэд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтална.”.

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсгийн “Шинжээч нь дараахь эрх эдэлнэ.” гэснийг “Шинжээч нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ.” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийн “энэ” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 85 дугаар зүйлийн 85.2, 85.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 5 дахь заалт, 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "цагдаа," гэсний дараа "шүүхийн шинжилгээний," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай: "31.2.Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална."

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-31.6, 31.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2009 оны 12 дугаар
сарын 03-ны өдөрУлаанбаатар
хот**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2009 оны 12 дугаар
сарын 03-ны өдөрУлаанбаатар
хот**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийн "энэ хуульд" гэснийг "Шүүхийн шинжилгээний тухай хуульд" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2009 оны 12 дугаар
сарын 03-ны өдөрУлаанбаатар
хот**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"47.2.Шинжлэх шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална."

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн "энэ хуулийн 47.5, 111.3-т заасан тохиолдолд" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-47.10 дахь хэсгийг хүчгүй болсонд тооцугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга" гэсний дараа ", шүүхийн шинжилгээний байгууллагын дарга" гэж, мөн зүйлийн 8.1.6 дахь заалтын "гаалийн байцаагч" гэсний дараа ", шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн "хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын" гэснийг "хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч" гэж, мөн зүйлийн 40.4 дэх хэсгийн "төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "Засгийн газрын гишүүн" гэж тус тус өөрчилсүгэй.



2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2009 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын Тогтворжуулалтын зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн үндсийг тодорхойлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, түүний удирдлага, үйл ажиллагаа, хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1 Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

¹ Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "үйлдвэрлэл, технологийн парк" /цаашид "парк" гэх/ гэж үйлдвэрлэл, технологийн хөгжлийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх тусгайлан нутаг дэвсгэр, бизнесийн таатай орчин, дэд бүтцийн хангамж бүхий, тодорхой салбарт үйл ажиллагаагаар харилцан уялдсан үйлдвэрлэл, технологи, үйлчилгээний цогцолборыг;

3.1.2. "паркийн удирдлага" гэж паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг;

3.1.3. "паркийн нэгж" гэж паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллагыг.

4 дүгээр зүйл. Парк байгуулах зорилго

4.1. Паркийг дараахь зорилгоор байгуулна:

4.1.1. шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах;

4.1.2. экспортын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг болон импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

4.1.3. байгаль орчинд халгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

4.1.4. бус нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих;

4.1.5. жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ПАРКИЙН ТАЛААР ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1. Улсын Их Хурал паркийн үйл ажиллагаа эрхлэх эдийн засаг, нийгэм, бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг тодорхойлно.

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

6.1. Засгийн газар паркийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.паркийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

6.1.2.паркийн үйл ажиллагааг төрөөс дэмжихэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор үнэт цэвс гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргах;

6.1.3.паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

6.1.4.паркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих асуудлаар холбогдох дүрэм, журам, заавар баталж мөрдүүлэх;

6.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1.Хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ паркийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.паркийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтийг хангуулах, хяналт тавих;

7.1.2.парк эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрлийн жагсаалтыг үйлдвэржүүлэлт, инновацийн бодлого, орон нутгийн дэд бүтцийн хөгжил, түүхий эд, ажиллах хүчний нөөц, зах зээлийн эрэлт, хэрэгцээг харгалзан тогтоох, шинэчлэх;

7.1.3.паркийнүйлажиллагааэрхлэхтусгайзөвшөөрөл/цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар санал боловсруулж, Засгийн газраар шийдвэрлүүлэх;

7.1.4.паржийн удирдлагатай гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих, дүгнэлт гаргах;

7.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

8.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал паркийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, дэд бүтцийн хөгжил, төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн паркийн нутаг дэвсгэр, байршлыг тогтоох;

8.1.2.паркийн үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих;

8.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

9.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга паркийн талаар дараахь бүрэн

эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1 тухайн нутаг дэвсгэрт паркийн үйл ажиллагааг дэмжих орон нутгийн хөтөлбөр батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.2 паркийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөлд хяналт тавих;

9.1.3 хуульд заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

10 дугаар зүйл. Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах

10.1 Дараахь шаардлагыг хангасан хуулийн этгээд парк байгуулах тухай хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргана:

10.1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан байх;

10.1.2. Монгол Улсад татаар төлөгч байх;

10.1.3. паркийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүү, эдийн засаг, технологи, менежментийн чадавхитай байх.

10.2. Төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар санал боловсруулахдаа дараахь баримт бичгийг үндэслэл болгоно:

10.2.1. паркийн техник, эдийн засгийн үндэслэл;

10.2.2. паркийн хөгжлийн төлөвлөгөө;

10.2.3. паркийн техник, технологийн түвшингийн үнэлгээ;

10.2.4. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

10.2.5. гэрээ байгуулах паркийн нэгжийн жагсаалт;

10.2.6. тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын Тэргүүлэгчдийн санал.

10.3. Засгийн газар энэ хуулийн 10.2-т заасан тусгай зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар олгоно.

10.4. Тусгай зөвшөөрлийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага паркийн удирдлагатай гэрээ байгуулна.

10.5. Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.4-т заасан гэрээг жил бүр дүгнэж, Засгийн газарт танилцуулна.

10.6. Энэ хуулийн 10.3-т заасан тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тохиолдолд гэрээний биелэлтийн дүнг үндэслэн Засгийн газар тусгай зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно.

11 дүгээр зүйл. Паркийн удирдлагын эрх, үүрэг

11.1. Паркийн удирдлага дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

11.1.1. төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах;

11.1.2. энэ хуулийн 10.2.5-д заасан жагсаалтад орсон паркийн нэгжтэй техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшингийн үнэлгээ, холбогдох байгууллагаар гаргуулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн гэрээ байгуулах;

11.1.3. паркийн үйл ажиллагаанд шаардлагатай үйлчилгээг үзүүлэх.

12 дугаар зүйл. Паркт хориглох үйл ажиллагаа

12.1. Паркт дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

12.1.1. согтууруулах ундааны үйлдвэрлэл;

12.1.2. тамхины үйлдвэрлэл;

12.1.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үйлдвэрлэл;

12.1.4. хуулиар хориглосон химийн хорт, цацраг идэвхт бодис ашиглах үйлдвэрлэл;

12.1.5. байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйл ажиллагаа;

12.1.6. хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа.

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

13.1. Эрх бүхий улсын байцаагч паркийн үйл ажиллагаанд дараахь зөрчил илэрсэн гэсэн дүгнэлт гаргасан тохиолдолд тухайн хуулийн этгээдэд олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай саналаа төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

13.1.1. паркийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа эрхлээгүй болон төлөвлөгөөнд зааснаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн;

13.1.2. төрөөс үзүүлсэн дэмжлэгийг зориулалтын бусаар ашигласан;

13.1.3. гэрээнд заасан хугацаанд үйл ажиллагаагаа эхлээгүй;

13.1.4. хууль болон гэрээнд заасан бусад тохиолдолд.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан дүгнэлтийг үндэслэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн² 13 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, сэргээх.

² Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



13.3.Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасныг зөрчсөн, эсхүл Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан үндэслэлээр паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

14 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

14.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эсхүл эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь захиргааны шийтгэлийг ногдуулна:

14.1.1.энэ хуулийн 12.1.1-12.1.5-д заасныг зөрчсөн иргэний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

14.1.2.энэ хуулийн 13.1.1-13.1.4-т заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 15.10.16 дахь заалт нэмсүгэй:

“15.10.16.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх.”



2 дугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 20.1.5 дахь заалт нэмсүгэй:

"20.1.5.үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр, байршлыг тогтоох."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

**Төрийн өмчөөс орон нутгийн өмчид
эд хөрөнгө шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2009 оны
90 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД
ШИЛЖҮҮЛЭХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

<i>№</i>	<i>Аймгийн нэр</i>	<i>Сумын нэр</i>	<i>Эд хөрөнгийн нэр</i>	<i>Нийт хөрөнгийн дүн /мян.төг/</i>
1	Баянхонгор	Баянхонгор	Аймгийн Прокурорын газрын хуучин барилга /291.8 м ² /, нам даралтын зуух, гүн эрмийн худал, аяган зам	18,430.45
ДҮН				18,430.45
2	Булган	Рашаант	Зам засвар арчлалтын тоосгон барилга	10,000.00
ДҮН				10,000.00
3	Булган	Гурванбулаг	Цэргийн оёдлын үйлдвэрийн барилга	8,421.90
ДҮН				8,421.90
4	Дархан-Уул	Орхон	Холбооны салбарын ашиглаж байсан хуучин барилга	17,040.00
ДҮН				17,040.00
5	Говь-Алтай	Есөнбулаг	Сурагчдын дотуур байрны барилга	85,573.40
ДҮН				85,573.40
6	Орхон	Баян-Өндөр	Согоот багийн 6 дугаар хорооллын 14 дүгээр байрны 20 айлын орон сууцны байр	700,000.00
ДҮН				700,000.00
7	Өмнөговь	Даланзадгад	Нийгмийн даатгалын хэлтсийн хуучин конторын барилга	18,234.10
ДҮН				18,234.10



8	Увс	Бөхмөрөн	Хилийн заставын эзэмшилд байсан барилга байгууламж:	
1			Халуун усны байр, гарааш	7,004.20
2			Албаны байр	12,180.00
3			Цэргийн байр	15,225.00
4			4 айлын орон сууц	8,755.20
5			Блокон хашаа	676.00
ДҮН				43,840.40
9	Төв аймаг	Батсүмбэр	Зөгийн аж ахуйн барилга	13,115.00
ДҮН				13,115.00
10	Хөвсгөл	Төмөрбулаг	Хуучнаар үржлийн фермийн:	
1			2 айлын орон сууц	1,620.48
2			Халуун усны байр	337.60
3			Гарааш	506.40
4			Тэжээлийн агуулах	337.60
5			Худаг, зам, талбай	392.40
ДҮН				3,194.48
НИЙТ ДҮН				917,849.73

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар
хот

Зэвсэгт хүчний Жанжин штабын тайван цагийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн тогтоох тухай

"Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 304 дүгээр зарлигаар батлагдсан "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 3.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:


1.Зэвсэгт хүчний Жанжин штабын тайван цагийн бүтэц, зохион байгуулалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү зарлигийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

ЦЭЛБЭГДОРЖ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 11 дугаар сарын 23-ны өдрийн 156 дугаар зарлигийн хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар
хот

Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай

"Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 1, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 267, 2009 оны 87 дугаар зарлигийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү зарлигийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009
оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн
158 дугаар зарлигийн хавсралт

ДЭЭД ОФИЦЕРЫН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЦЭРГИЙН ЦОЛНЫ ЗЭРЭГЛЭЛ

д/д	Албан тушаалын ангилал	Албан тушаалын тоо	Цэргийн цолны зэрэглэл
1.	Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга	1	Дэслэгч генерал
2.	Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга	1	Хошууч генерал
3.	Хил хамгаалах ерөнхий газрын дарга	1	Хошууч генерал
4.	Зэвсэгт хүчний Жанжин штабын дэд дарга	1	Хошууч генерал
5.	Цагдаагийн ерөнхий газрын дарга бөгөөд Дотоодын цэргийн дарга	1	Хошууч генерал

6.	Ерөнхий зохицуулалтын цэргийн командлагч	1	Хошууч генерал
7.	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч	1	Бригадын генерал
8.	Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын дарга	1	Бригадын генерал
9.	Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хилийн цэргийн штабын дарга	1	Бригадын генерал
10.	Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга	2	Бригадын генерал
11.	Талнуулын ерөнхий газрын дэд дарга	1	Бригадын генерал
12.	Батлан хамгаалахын их сургуулийн захирал	1	Бригадын генерал
13.	Зэвсэгт хүчний Жанжин штабын газрын дарга нар /J3, J4, J5/	3	Бригадын генерал
14.	Зэвсэгт хүчний ерөнхий хянан шалгагч	1	Бригадын генерал
15.	Ерөнхий зориулалтын цэргийн штабын дарга	1	Бригадын генерал

Тайлбар: 1.Хавсралт дахь албан тушаалын ангилалд харгалзсан цэргийн цолны зэрэглэл нь эдгээр албан тушаалд томилогдсон цэргийн бус хүнд хамаарахгүй.

2.Цэргийн дээд цолтонг цэргийн дипломат албанд томилж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 303

Улаанбаатар
хот

"Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хоёр дахь хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хоёр дахь хөтөлбөрийг 1 дүгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг

2010 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсөөт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн П улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД**

Н.АЛТАНХУЯГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

Засгийн газрын 2009 оны 303 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**"СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХОЁР
ДАХЬ ХӨТӨЛБӨР**

**Нэг. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн
өнөөгийн байдал**

Дэлхийн хэмжээнд 2005 онд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 10 хувийг сэтгэц, зан үйлийн эмгэг эзэлж байсан бол 2020 онд 15 хувь болж нэмэгдэх магадлалтай байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (цаашид "ДЭМБ" гэнэ) тооцоолсон байна. Өнөөгийн байдлаар дэлхийн 4 хүн тутмын 1 нь сэтгэцийн ямар нэг эмгэгт нэрвэгдэж байгаагаас гадна хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэдэг 10 өвчний 5 нь сэтгэцийн эмгэг байна.

Сүүлийн 25 жилд манай улсад сэтгэц, зан үйлийн эмгэгийн тархалтын судалгаа хийгдээгүй бөгөөд эрүүл мэндийн статистик мэдээгээр сэтгэц, зан үйлийн эмгэгийн тохиолдол 2000 онд 10000 хүн амд 77.4 байсан бол 2007 онд 112.9 болж нэмэгджээ. 2008 оны байдлаар манай улсад сэтгэц, зан үйлийн эмгэгтэй 22 мянга гаруй хүн эмнэлгийн идэвхтэй хяналтад эмчлэгдэж, хөдөлмөрийн чадвар алдсан нийт хүний дотор сэтгэцийн эмгэгтэй хүн 15 хувийг эзэлж байна.

Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор Засгийн газраас 2002-2007 онд "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн юм. Энэ хугацаанд "Эрүүл мэндийн боловсрол" бага, дунд боловсролын улсын стандарт, ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр, сурах бичиг болон багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын агуулга, хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг тусгаж, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил тогтмолжин, сум, өрхийн түвшинд сэтгэцийн эрүүл

мэндийн анхан шатны тусламж үзүүлдэг болсон бөгөөд уг үйлчилгээнд хамрагдах хүний тоо нэмэгдсэн байна. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг гэр бүл, нийгмийн дунд амьдрах дадал хэвшилтэй болгоход чиглэсэн сэтгэц-нийгмийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлдэг "Гэр" төв, тусгай тохиожуулсан байр нийслэл төдийгүй Ховд, Орхон, Өвөрхангай, Дорноговь зэрэг аймагт нээгдэж үйл ажиллагаа нь тогтмолжсон зэрэг ололт гарсан юм.

Гэвч үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр хөтөлбөрийн гол шалгуур үзүүлэлт ялангуяа, хүн амын дунд сэтгэц, зан үйлийн эмгэгийн тархалт болон амиа егүүтгэх тохиолдол буураагүй байна. Иймд хүн амын дунд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих урт хугацааны үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь чухал байгаагийн дээр Монгол Улсад сэтгэцийн эрүүл мэндийн дараахь тулгамдсан асуудал байна:

Нэгдүгээрт, сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хангах асуудлыг Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор гарсан эрх зүйн баримт бичигт тусгасан боловч сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал түгээмэл байна.

Хоёрдугаарт, сэтгэц нөлөөт шинэ эмийг эмчилгээнд нэвтрүүлэх боломж хязгаарлагдмал байна. Дэлхий нийтэд 200 гаруй нэр төрлийн сэтгэц нөлөөт шинэ эмийг эмчилгээнд хэрэглэж байхад Монгол Улс зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад бүртгэгдсэн, эмчилгээний үр дүн багатай, гаж нөлөө ихтэй 10 нэр төрлийн эмийг сүүлийн 50 жилийн турш хэрэглэсээр ирсэн. Түүний зэрэгцээ эдгээр эмийн хангамж, хүрэлцээ сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд ялангуяа сум, өрх, аймаг, дүүргийн түвшинд хангалтгүй байна.

Гуравдугаарт, дэлхий нийтэд сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлэгт суурилсан тусламжаас татгалзаж, нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж, үйлчилгээг түлхүү хөгжүүлж байхад манай улсад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардлын 64 хувийг ор бүхий эмнэлгийн тусламж үйлчилгээнд зарцуулж байгаагаас нийгэм, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах боломж хязгаарлагдмал байна.

Дөрөвдүгээрт, эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ур чадвар дутмаг байна. 1997-2006 онуудад хандивлагч байгууллагын санхүүжилтээр "Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ" сэдэвт сургалт зохион байгуулж, нийт 1300 гаруй өрхийн эмчийг хамруулсан боловч сургалтад хамрагдсан эмч нарын 60 хувь нь ажил, мэргэжлээ өөрчилсөн байна.

"Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө"-нд 2015 он гэхэд сэтгэц, зан үйлийн эмгэгийг 10000 хүн амд 65 хүртэл бууруулах, сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж шаардлагатай үйлчлүүлэгчдийн 70 хүртэлх хувийг тусламж үйлчилгээнд хамруулахаар төлөвлөсөн бөгөөд хүн амын дунд сэтгэц, зан үйлийн эмгэгийн тохиолдол, амиа хорлолт буурахгүй байгааг харгалзан "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөёр дахь хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэнэ)-ийг боловсруулсан болно.

Хөёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго нь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны болон нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж, үйлчилгээг өргөжүүлэх замаар сэтгэц, зан үйлийн эмгэгийн тархалтыг бууруулах нөхцөл бүрдүүлэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Зорилт 1. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлнэ;

2.2.2. Зорилт 2. Сэтгэцийн эрүүл мэндээ хянаж сайжруулах талаар хувь хүний мэдлэг, чадварыг дээшлүүлнэ;

2.2.3. Зорилт 3. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд нийгэм, хамт олны оролцоог нэмэгдүүлнэ;

2.2.4. Зорилт 4. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож хүртээмж, чанарыг сайжруулна;

2.2.5. Зорилт 5. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйл, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалтыг сайжруулна.

Гурав. Хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.1. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

3.1.1. сэтгэцийн эрүүл мэндийн талаархи шийдвэр гаргагчдын мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг өргөжүүлэх;

3.1.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан эрх зүйн баримт бичигт үнэлгээ хийж боловсронгуй болгох;

3.1.3. сэтгэцэд нөлөөт эмийн хангамжийг сайжруулах, сэтгэцэд нөлөөт шинэ эмийг эмчилгээ, үйлчилгээнд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;

3.1.4. сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл

ажиллагаанд зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлж, нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээнд түлхүү хуваарилах;

3.1.5. сэтгэцийн эрүүл мэндэд ээлтэй ажлын байр, сургууль, хамт олон бий болгох ажлыг аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны нэг хэсэг болгон зохион байгуулах;

3.1.6. сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар гарын авлага, зөвлөмж гаргаж байгууллага, хамт олны дунд сургалт явуулах, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх.

Хүрэх үр дүн: Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдэнэ.

3.2. Сэтгэцийн эрүүл мэндээ хянаж сайжруулах талаар хувь хүний мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.2.1. ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хнээлийн хөтөлбөр болон багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын агуулга, хөтөлбөрт байгаа сэтгэцийн эрүүл мэндийн талаархи асуудлыг шинэчлэн, боловсронгуй болгох, багшлах хүний нөөцийн чадварыг дээшлүүлэх;

3.2.2. бухимдал тайлах, сэтгэл хөдлөлөө хянаж зохицуулах, харилцааны соёлоо дээшлүүлэх, бусдыг сонсох, бүтээлчээр сэтгэх, тулгамдсан асуудлыг зүй зохистой шийдвэрлэх талаар хүүхэд, залуучууд, нийт хүн амын мэдлэгийг сайжруулах чиглэлээр албан бус, зайны сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж сургалт явуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

3.2.3. дасгал хөдөлгөөн, бясалгал зэрэг хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

3.2.4. сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах болон сэтгэцийн эрүүл мэнд, амьдрах үр чадвар, сэтгэцийн эмгэгийн тухай ташаа ойлголт, хандлагыг өөрчлөхөд хэвлэл, мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах, сэтгүүлч нарт зориулсан сургалт явуулах.

Хүрэх үр дүн: Иргэд харилцааны соёлоо дээшлүүлэх, бусдыг сонсох, бүтээлчээр сэтгэх, тулгамдсан асуудлыг зүй зохистой шийдвэрлэх, сэтгэл хөдлөлөө хянаж зохицуулах, бухимдлаа тайлах талаар зөв дадал хэвшилтэй болно.

3.3. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд нийгэм, хамт олны оролцоог нэмэгдүүлэх талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3.1. сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд,

гэр бүл, хамт олны оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийн уралдаан зарлаж дүгнэх, урамшуулах, сурталчлах, гэрээ байгуулах замаар хамтран ажиллах;

3.3.2. нийгэм, хамт олны дунд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх;

3.3.3. сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн гэр бүлийн болон еөртөө туслах бүлэг, нийгэмлэг, холбоо байгуулах үүсгэл, санаачилга, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд оролцуулах;

3.3.4. нийгэм, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа хүний нөөцийн чадавхийг сайжруулах;

3.3.5. ажлын байрны таагүй орчин, хамт ажиллагсдын зүгээс үзүүлэх дарамт шахалт зэрэг хүний сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг тогтоож шалтгаан, үр дагаврыг бууруулах асуудлаар аргачлал, зөвлөмж гаргаж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх.

Хүрэх үр дүн: Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гэр бүл, хамт олны оролцоо нэмэгдэн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олны тоо нэмэгдэнэ.

3.4. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож хүртээмж, чанарыг сайжруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

3.4.1. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар;

3.4.1.1. сум, өрхийн эмнэлгээс үзүүлж байгаа сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байдалд үнэлгээ хийж хүртээмж, чанарыг сайжруулах арга хэмжээ авах;

3.4.1.2. хүүхэд, өсвөр үе, ахмад настны сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах;

3.4.1.3. аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт сэтгэцийн эмгэгтэй өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлэх орны тоог нэмэгдүүлж, иргэдийг орон нутаг, гэр орондоо ойр эмчлүүлэх боломж бүрдүүлэх;

3.4.1.4. хууль ёсны асран хамгаалагчгүй боловч асран хамгаалагчийн ивээлд байх шаардлагатай сэтгэцийн архаг эмгэгтэй хүнд зориулсан улсын асрамжийн газар байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

3.4.1.5. сэтгэц-нийгмийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх талаар нутгийн захиргаа, нийгмийн халамжийн байгууллагатай хамтран ажиллах, аймаг, дүүрэгт сэтгэц-нийгмийн нөхөн сэргээх "Гэр" төв, кабинет байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах;

3.4.1.6. сэтгэцийн эмгэгтэй хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй уялдуулан зохион байгуулах.

3.4.2. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг оновчтой болгох талаар;

3.4.2.1. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээнд түлхүү хуваарилах;

3.4.2.2. сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байгаа нөөцийг дайчлах арга хэмжээ авах;

3.4.3. сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хангах талаар;

3.4.3.1. сэтгэцийн тусламж, үйлчилгээний ор бүхий аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт магадлан тогтоох комисс байгуулж ажиллуулах;

3.4.3.2. сэтгэцийн эмгэгийн улмаас албадан эмчилгээнд орсон тохиолдол бүрийг хянаж, магадлан тогтоох комиссоор хэлэлцэн шийдвэрлэж, энэ талаархи мэдээллийг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж байх;

3.4.4. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хангамж, чадавхийг сайжруулах талаар;

3.4.4.1. анагаах ухааны болон сувилахуйн сургуулийн төгсөх курсийн өмнөх болон дараахь сэтгэцийн эрүүл мэндийн сургалтын агуулга, хөтөлбөрийг шинэчлэх;

3.4.4.2. сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний талаар сум, өрхийн эмч нарт сургалт явуулах, ажлын байран дээр нь сургах, дадлагажуулах;

3.4.4.3. хүүхэд, өсвөр үе, ахмад настны сэтгэцийн эрүүл мэнд, шүүхийн сэтгэц эмгэг судлал, сэтгэл зүй, сэтгэл засал, хэл засал, эмгэг сэтгэл зүй, гамшгийн үеийн сэтгэцийн эрүүл мэнд зэрэг төрөлжсөн нарийн мэргэжлээр эмч, мэргэжилтэн гадаад, дотоодод бэлтгэх, мэргэшүүлэх;

3.4.4.4. сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг төрөх, эмэгтэйчүүд, хүүхэд, хавдар, дотор зэрэг бусад нарийн мэргэжлийн тусламжтай уялдуулах чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, дадлыг дээшлүүлэх сургалт явуулах;

3.4.4.5. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал бүрт



нэмэгдүүлэх, гадаад, дотоодод сургах, мэргэшүүлэх;

3.4.5. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар:

3.4.5.1. зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамжийг шинээр болон шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;

3.4.5.2. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа нийт байгууллагын үйл ажиллагааг магадлан итгэмжлэх;

3.4.5.3. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн шаардлагад нийцсэн оношилгоо, эмчилгээний шинэ арга, технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.4.5.4. зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, хангамжийг сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалд ялангуяа сум, өрх, аймаг, дүүргийн түвшинд нэмэгдүүлэх, орон нутагт үнэгүй эм олгох нөхцөлийг бүрдүүлэх.

Хүрэх үр дүн: Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, хүний нөөцийн чадавхи сайжирна.

3.5. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйл, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалтыг сайжруулах талаар дарваахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

3.5.1. хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийн тандалт судалгааг тогтмол хугацаанд явуулж, тандалтын дүнд үндэслэн бодлого, стратеги боловсруулах, холбогдох өөрчлөлтийг оруулах, баримт нотолгоонд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах;

3.5.2. сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийн тандалт хийх талаар байгууллага, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, энэ чиглэлээр олон улсын байгууллага, хандивлагч орноос дэмжлэг авах;

3.5.3. сэтгэцийн эрүүл мэндийн мэдээллийн санг өргөжүүлж ашиглалтыг сайжруулах.

Хүрэх үр дүн: Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйл, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалт болон мэдээллийн үндэсний тогтолцоо бэхжинэ.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулна.

4.2. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг Засгийн газарт тайлагнана.

4.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

4.4. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг эрүүл мэндийн бусад хөтөлбөр, төслийн үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, үе шат, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг 2010-2019 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

5.1.1. Нэгдүгээр үе шат 2010-2014 он;

5.1.2. Хоёрдугаар үе шат 2015-2019 он.

5.2. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.2.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

5.2.2. Засгийн газрын зарим тусгай сан (Шинжлэх ухаан технологийн сан, Эрүүл мэндийг дэмжих сан)-гийн хөрөнгө;

5.2.3. гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.2.4. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;

5.2.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт

6.1. Үндэсний хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх, хөтөлбөрийг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулах ажлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох яам, байгууллагатай хамтран зохион байгуулах бөгөөд шаардлагатай бол хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэж болно.

6.2. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх ажлыг бүх шатны Засаг дарга хариуцна.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Үзүүлэлтүүд	2009 оны суурь түвшин	2014 онд хүрэх түвшин	2019 онд хүрэх түвшин	Мэдээний эх үүсвэр
Наг Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх талаар					
1.1	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, аж ахуйн нэгж /ажлын байр, сургууль, эмнэлэг/, хамт олны тоо	265	20 хувиар нэмэгдүүлнэ	50 хувиар нэмэгдүүлнэ	Эрүүл мэндийн газрын мэдээ
1.2	Эмчилгээ үйлчилгээнд нэвтрүүлсэн сэтгэгдэл нөлөөт шинэ эмийн тоо, төрөл	-	2	4	•
1.3	Сүүлийн 5 жилд сэтгэцийн эрүүл мэндийн сургалтад хамрагдсан цагдаа, шүүх, хуулийн ажилтны эзлэх хувь	20	50	70	•
Хоёр Иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн мэдлэг, чадавцыг дээшлүүлэх талаар					
2.1	Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар ажил зохиодог ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь*	20	50	70	•
Гурав. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд олон нийт, хамт олны оролцоог нэмэгдүүлэх талаар					
3.1	Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг ТББ-ын тоо	2	3	4	•
Дөрөв. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож хүртээмж, чанарыг сайжруулах талаар					
4.1	Сэтгэцийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн орны тоо (10000 хүн амд)	4.47	10 хувиар буурна	15 хувиар буурна	Эрүүл мэндийн статистик үзүүлэлт

4.2	Аймаг, дүүргийн ногдсан эмнэлгийн сэтгэцийн тусламж үйлчилгээний орны тоо (10000 хүн амд)	1.19	10 хувийг нэмэг-дэнэ	15 хувийг нэмэгдэнэ	Эрүүл мэндийн статистик үзүүлэлт
4.3	Нийгэм хамт олны дунд ажиллаж байгаа "Тэр" төвийн тоо	12	14	16	СЭМҮТ-ийн статистик мэдээлэл
4.4	Аймаг, дүүргийн түвшинд ажилладаг сэтгэцийн эмчийн тоо (10000 хүн амд)	0.2	0.25	0.3	Эрүүл мэндийн статистик үзүүлэлт
4.5	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний талаарх сургалтад хамрагдсан сум, өрхийн эмчийн эзлэх хувь	25	60	85	СЭМҮТ-ийн статистик мэдээлэл
4.6	Ангаах ухааны болон сувиллахуйн сургалтын хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэндийн хичээлийн цагийн эзлэх хувь	1-5	10	15	ЭМШУИС-ийн Сургалтын албаны мэдээлэл
4.7	Зөйлшгүй шаардлагатай эмийн үндэсний жагсаалтад орсон сэтгэц нөлөөт эмээр хангагдсан аймаг, дүүргийн ногдсан эмнэлэг, сум, өрхийн эмнэлгийн эзлэх хувь	86	95	100	СЭМҮТ-ийн статистик мэдээлэл

Тайлбар: (*)-Монгол Улсын сэтгэцийн эрүүл мэндийн тогтолцоог ДЭМБ-ын "Сэтгэцийн эрүүл мэндийн тогтолцоог үнэлэх стандарт аргачлал (шалгуур үзүүлэлт)"-аар үнэлсэн тухай тайлан, 2006 он

**"СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД" - ҮНДЭСНИЙ ХОЁР ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 2010-2019 ОН**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа
1.1	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тэдгэрийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан эрх зүйн баримт бичигт үндэслэл хийж боловсронгуй болгох	ЭМЯ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /СЭМУТ/	ХЗДХЯ, НХХЯ, ТББ	2010-2012
1.2	Сэтгэцэд нөлөөт шинэ эмийн талаар мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар шийдвэр гаргалч нарт зориулсан уулзалт, сургалт зохион байгуулах	ЭМЯ, СЭМУТ	ХЗДХЯ, НХХЯ, ДЭМБ, ТББ	2010-2012
1.3	Бус, нутгийн онцлогт тохируулан сэтгэцийн эрүүл мэндийн бодлого, дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх талаар орон нутгийн шийдвэр гаргалч нарт зориулсан семинар зохион байгуулах	ЭМЯ, СЭМУТ	ЭМГ, Аймэг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ	2010-2012
1.4	Хөдөлмөрийн чадвараа алдаагүй, сэтгэцийн архаг эмгэгтэй хүнийг ажлын байраар хангах, сэтгэцийн эмгэгтэй хүн хувиараа хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх тухай холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	НХХЯ	МХЕГ, ЭМЯ СЭМУТ, Хүний эрхийн комисс	2010-2011
1.5	Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах асуудлаархи үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг гадаад орон, олон улсын байгууллагад тавьж хамтран ажиллах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	ГХЯ	ЭМЯ, НХХЯ	2010-2019

1.6	Арих, тамхи, бусад сэтгэгдэл нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих асуудлаархи олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, холбогдох байгууллагатай хамтарсан уулзалт, сургалт зохион байгуулах	ГХЯ	ЭМЯ, ХЗДХЯ ЦЕГ, ЭЦГ	2010-2019
1.7	Хүүхэд, өсөөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн орчин бүрдүүлэх талаар бүх шатны боловсролын байгууллагад зориулан журам, заавар гаргаж хэрэгжүүлэх	БСШУЯ	ЭМЯ ЭМГ ДЭМБ	2010-2011
1.8	Ажлын байрыг эрүүл ахуйн шаардлага хангасан, аюул осолгүй, тав тухтай, сэтгэл зүйн таатай орчин болгоход чиглэсэн заавар, журам гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиглах, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах	НХХЯ	ЭМЯ, Аж ахуйн нэгж, байгууллага, ТББ	2010-2011
1.9	Аймаг, дүүрэгт сэтгэц-нийгмийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ шинээр бий болгоход зориулан гэр, хашаа, орон байр олгох асуудлыг шийдвэрлэх	Аймаг, нийслэлийн ЗДТГ	НХХЯ, ЭМЯ ТББ	2010-2018
Хоёр, Сэтгэцийн эрүүл мэндээ хянаж сайжруулах талаар хувь хүний мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд				
2.1	Бүх шатны сургуулийн эрүүл мэндийн хичээлийн сургалтын агуулга, хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэнд, амьдрах үр чадварын мэдлэг эзэмшүүлэх асуудлыг цогц байдлаар тусгах	БСШУЯ	ЭМЯ, СЭМУТ, ДЭМБ	2010-2012
2.2	Тулгамдсан асуудлыг зүй зохиотой шийдвэрлэх, амьдрах үр чадвар эзэмшүүлэх албан бус, зайны сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж, сургалт явуулах	БСШУЯ	ЭМЯ, СЭМУТ, ДЭМБ	2011-2019

	Сэтгэцийн эрүүл мэндийн сургалт явуулах өргө зүйн гарын авлага боловсруулах	ЭМЯ, СЭМУТ	БСШУЯ, ЭМШУИС	2010
2.3	Амьдрах ур чадвар, сэтгэцийн эрүүл мэндийн талаар олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмолжуулах	ЭМЯ, СЭМУТ	МУОНРТ, ЭМГ, ДЭМБ	2010-2019
2.4	Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээл заадаг багш нарт сургалт явуулах	ЭМЯ, СЭМУТ	БСШУЯ	2010-2017
2.6	Сэтгэцийн эрүүл мэндийн талаар хөвлөл, мэдээллийн ажилтнуудад зориулсан уулзалт, сургалт зохион байгуулах	ЭМЯ, СЭМУТ	ДЭМБ, ТББ	2010-2012
2.7	Дасгал хөдөлгөөн, бөсөлтэй зэрэг сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа, туунд хамрагдагсдын хүрээг өргөжүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх	ЭМЯ, СЭМУТ	ТББ	2010-2019
	Гурав. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд нийгэм, хамт олны оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд.			
3.1.	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах талаар холбогдох яам, байгууллагад уулзалт, сургалт зохион байгуулах	ЭМЯ, СЭМУТ	ДЭМБ	2010-2011
3.2	Нийгэм, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллага, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн өөртөө туслах бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	ЭМЯ, СЭМУТ	ДЭМБ	2010-2019
3.3	Нийгэм, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг сургалтад хамруулах, гарын авлагаар хангах	ЭМЯ, СЭМУТ	ЭМШУИС, ДЭМБ	2010-2014

3.4	Ажлын байрны таагүй орчин, хамт ажиллагсдын зүгээс үзүүлэх дарамт шахалт зэрэг хүний сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг тогтоож шалтгаан, үр дагаврыг бууруулах талаар арга-члал, зөвлөмж гаргаж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авах	ЭМЯ, СЭМҮТ	НХХЯ, ЭМШУИС, ДЭМБ, ТББ	2010-2011
3.5	Сэтгэцийн эрүүл мэндэд ээлтэй байгууллага, хамт олноыг шалгаруулах уралдаан зохион байгуулах	ЭМЯ, СЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ	2011-2019
3.6	Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар сонгогдсон ажлын байр, хамт олонд сургалт явуулах	ЭМЯ, СЭМҮТ	ЭМГ, ДЭМБ	2011-2019
3.7	Хөтөлбөрийн бодлого, чиглэлд нийцүүлэн өөрийн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд үндэслэн сэтгэцийн эрүүл мэндийн дэд хөтөлбөр боловсруулан баталж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Аймаг, нийслэлийн ИТХ	2010
3.8	Сэтгэцийн эрүүл мэндийн дэлхийн өдрийг тэмдэглэх	ЭМЯ, СЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	Жил бүрийн X/10
3.9	Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эмгэг, сэтгэцийн эмгэгтэй хүний талаар зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах, энэ талаар нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авах	МҮОНРТ, Бусад хэвлэл, мэдээллийн байгууллага	ЭМЯ, НХХЯ, БСШУЯ, ТББ	2010-2019
Дөрөв, Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож хүртээмж, чанарыг сайжруулах зорилтын хүрээнд				
4.1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар				

4.1.1	Хүүхэд, өсвөр үеийнхэн, ахмад настанд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгэм, хамт олны дунд бий болгох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагаатай хамтран ажиллах	ЭМЯ, СЗМУТ	НХХЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ЭМГ, ХТТ, ДЭМБ, НҮБХС, ТББ	2010-2015
4.1.2	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийг хөгвөрлөхөд чиглэсэн оношилгоо, эмчилгээний бүдүүвч боловсруулан гаргаж сум, өрхийн эмнэлгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх	ЭМЯ, СЗМУТ	ДЭМБ	2010-2011
4.1.3	Сэтгэцийн эмгэгтэй хүнд зориулсан сэтгэц-нийгмийн нөхөн сэргээх өдрийн болон асрамжийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх талаар хамтарсан уулзалт, ярилцлага зохион байгуулж зөвлөмж гарган хэрэгжүүлэх	ЭМЯ, НХХЯ, СЗМУТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ТББ	2010-2019
4.1.4	Аймаг, дүүрэгт сэтгэц-нийгмийн нөхөн сэргээх "Гэр" төв, кабинет шинээр байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	ЭМЯ	НХХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ТББ	2010-2019
4.1.5	Аймаг, дүүргийн түвшинд сэтгэцийн болон донтох эмгэгийг эмчлэх орны тоог нэмэгдүүлэх талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	ЭМЯ, СЗМУТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	2010-2011
4.1.6	Эрх зүйн чадамжгүй, өсрөн хамгаалагч шаардлагатай боловч өсрөн хамгаалагчгүй сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдэд зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх	НХХЯ	ЭМЯ, СЗМУТ, ДЭМБ	2011-2012
4.1.7	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал хоорондын уялдаа, холбоог сайжруулах зорилгоор холбогдох журам гаргаж хэрэгжүүлэх	ЭМЯ, СЗМУТ	Аймаг, дүүргийн ЗДТГ, ЭМГ	2010

4.1.8	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нийгэм, хамт олны дунд зохион байгуулах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, загвар төсөл хэрэгжүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	Аймаг, дүүргийн ЗДТГ, ЭМГ, ДЭМБ, ТББ	2010-2012
4.1.9	Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй уялдуулан нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулах боломжийг судалж шийдвэрлэх	НХХЯ	ЭМЯ, СЭМҮТ Аймаг, дүүргийн ЗДТГ, ХХҮГ ЭМГ, ДЭМБ, ТББ	2010-2012
4.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг оновчтой болгох талаар				
4.2.1	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулж байгаа санхүүжилтийн байдалд үнэлгээ хийж оновчтой болгох талаар салбар дундын уулзалт, ярилцлага зохион байгуулж хэлэлцүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	НХХЯ, СЯ	2010-2011
4.2.2	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг оновчтой болгох талаар аймаг, нийслэл болон дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зориулсан сургалт, семинар зохион байгуулах	ЭМЯ, СЭМҮТ	НХХЯ, СЯ	2010-2014
4.3. Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хангах талаар				
4.3.1	Сэтгэцийн тусламж үйлчилгээний ор бүхий аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт магадлан тогтоох комисс байгуулж ажиллуулах	ЭМЯ, СЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	2010
4.3.2	Сэтгэцийн эмгэгийн улмаас албадан эмчилгээнд орсон тохиолдол бүрийг магадлан тогтоох комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байх, энэ талаархи мэдээллийг дээд шатны байгууллагад хүргүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	2010-2019

4.3.3	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хангах талаар сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад явуулах сургалтыг тогтмолжуулах	ЭМЯ, СЭМҮТ	Хүний эрхийн комисс, ДЭМБ, ТББ	2010-2019
4.4. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хангамж, чадавхийг сайжруулах талаар				
4.4.1	Анагаах ухааны болон сувиллахуйн сургуулийн төгсөлтөй өмнөх болон дараахь сэтгэцийн эрүүл мэндийн сургалтын агуулга, хөтөлбөрийг шинэчлэх	БСШУЯ, ЭМШУИС	СЭМҮТ	2010
4.4.2	Сэтгэцийн эмч бэлтгэх резидентурын 2 жилийн сургалтын гарын авлага, хөтөлбөрийг хөндөж, шинэчлэн боловсруулж, хэвлүүлэх	БСШУЯ, ЭМШУИС	СЭМҮТ	2010-2012
4.4.3	Сэтгэцийн сувилалч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, ахуйн засалч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулах	ЭМЯ, СЭМҮТ	Аймаг, дүүргийн ЭМГ	2011-2012
4.4.4	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн талаархи сум, өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалтыг үе шаттайгаар тасралтгүй зохион байгуулах, ажлын байран дээр нь сургаж дэдлагажуулах	ЭМЯ, СЭМҮТ	ЭМШУИС, Аймаг, нийслэлийн ЭМГ, ДЭМБ	2010-2019
4.4.5	Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг төрөх эмэгтэйдүүд хүүхэд, хавдар, дотор зэрэг бусад нарийн мэргэжлийн тусламжтай үйлдүүлэх чиглэлээр гарын авлага гаргаж эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт явуулах	ЭМЯ, СЭМҮТ	ЭМШУИС, ДЭМБ	2010-2018
4.4.6	Хүүхэд, өснөр үе, ахмад настны сэтгэцийн эрүүл мэнд, шүүхийн сэтгэл эмгэг судлал, сэтгэл зүй, сэтгэл засал, хэл засал, эмгэг сэтгэл зүй, гэмшлийн үеийн сэтгэцийн эрүүл мэнд зэрэг төрөлжсөн нарийн мэргэжлээр эмч, мэргэжилтэн бэлтгэх сургалт зохион байгуулах, гадаадад хүн сургаж мэргэшүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	БСШУЯ, ЭМШУИС, ДЭМБ	2010-2019

4.4.7	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн талаар зайны сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулан сургалт явуулах	ЭМЯ, СЭМҮТ	БСШУЯ, ЭМШУИС, ДЭМБ	2011-2019
4.5. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар				
4.5.1	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа бүх төрлийн байгууллагын стандартыг шинэчлэн боловсруулах	ЭМЯ, СЭМҮТ	ЭМГ, СХЗГ	2010-2012
4.5.2	Зөвхион тохиолдох сэтгэцийн эмгэгийн оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлгэйн удирдамжийг шинэчлэх	ЭМЯ, СЭМҮТ	СХЗГ	2010-2011
4.5.3	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа нийт байгууллагын үйл ажиллагааг магадлан итгэмжлэх	ЭМЯ, СЭМҮТ	ЭМГ	2011-2014
4.5.4	Сум, өрхийн эмнэлгээр үзүүлж байгаа сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байдалд үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	ДЭМБ	2010-2012
4.5.5	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн шаардлагад нийцсэн оношилгоо, эмчилгээний шинэ арга технологи нэвтрүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	СЯ	2010-2019
4.5.6	Зөвшөөрөгч шаардлагатай сэтгэгдэл нөлөөт эм, үнэгүй олгодог эмийн хангамжийн байдлыг аймаг, дүүргийн түвшинд үнэлж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	2010-2011
Тав. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйл, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалтыг сайжруулах зорилтын хүрээнд:				
5.1	Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйл, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалт судалгааг тогтмол хугацаанд явуулах, олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас дэмжлэг авах	ЭМЯ, СЭМҮТ	БСШУЯ, ЭМШУИС, ДЭМБ	2010 2014 2019

5.2	Сэтгэцийн эрүүл мэндийн байдал, гүүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйл, зохиолон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалтын талаар байгууллага, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх сургалт явуулах	ЭМЯ, СЭМҮТ	БСШУЯ, ЭМШУИС ДЭМБ	2010-2014-2019
5.3	Сэтгэцийн эрүүл мэндийн талаар одоо байгаа тоо, баримтыг нэгтгэн гаргаж жэжлүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	БСШУЯ, ЭМШУИС ДЭМБ	2010-2011
5.4	Зохиолон тохиолдог сэтгэцийн эмгэгийн эмчлэгээний үр дүн, сэтгэцийн эмгэгийн өртөг зардлын талаар судалгаа хийх	ЭМЯ, СЭМҮТ	БСШУЯ, ЭМШУИС, НЭМХ, ЭМГ, ДЭМБ	2012-2013
5.5	Сэтгэцийн эрүүл мэндийн мэдээллийн санг өргөжүүлэх талаар бусад орны туршилагатай танилцан холбогдох байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр санал боловсруулж шийдвэрлүүлэх	ЭМЯ, СЭМҮТ	НЭМХ, ЭМГ, ЭМШУИС, ДЭМБ	2010-2011
5.6	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийг аймаг, дүүргийн эмнэлэгтэй холбосон цахим сүлжээтэй болгох	ЭМЯ, СЭМҮТ	ДЭМБ, Олон улсын төсөл хөтөлбөр	2011-2013

Тайлбар: ЭМГ –Эрүүл мэндийн газар

ХХҮГ –Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

ХТТ –Хүүхдийн төлөө газар

СЭМҮТ –Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

НЭМХ –Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн

ЭМШИУС –Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

МУОНРТ –Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз

СХЗГ –Стандартчилал, хэмжил зүйн газар

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакц,

Улаанбаатар-12, Төрийн ордон 128 тоот

И-мэйл: turin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 3.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв,
Утас 329487